

**2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БАТТОГТОХЫН ӨЛЗИЙСАЙХАНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 7 дугаар сарын 24-ний өдөр

Эрдэнэт хот


Баттогтохын Өлзийсайхан миний бие 2020 оны Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвших хүсэлтээ илэрхийлж, Монгол улсын үндсэн хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжууд, холбогдох баримт бичгүүдийг удирдлага болгон энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулсан болно.

**Иргэн бүр бизнес эрхлэхэд таатай хот:**

- ❖ Ажлын туршлага, ур чадвартаа түшиглэн өөрөө өөртөө ажлын байр бий болгох санаачлагыг дэмжиж, иргэн бүрт тэгш боломж олгох нөхцлийг бүрдүүлэх
- ❖ Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж татварын хялбаршуулсан байдлаар тооцдог журмын хэрэгжилтийг сайжруулах
- ❖ Төмс, хүнсний ногоо болон өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн хэмжээнд дотооддоо хангах бодлогыг баримтлах
- ❖ Шинээр ажлын байрыг бий болгох, аж ахуй эрхлэх бүтээлч санаачлагыг дэмжиж, бичил, жижиг дунд бизнесийг санхүү болон мэдлэг олгох сургалтуудаар дэмжих бодлогыг баримталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- ❖ Орон нутгийн дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлийг хамгаалах, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримталж ажиллах
- ❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг орон нутгийн хувийн хэвшилд тэгш, хүртээмжтэй олгох замаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлийн бодлогыг баримталж ажиллах

**Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой-Эрдэнэт хот:**

- ❖ Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олгож буй орон нутгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах
- ❖ Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чадавхийг сайжруулах, хавдар, зүрх судас, гэмтэл согог, эх нялхсын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, орон нутагтаа чанартай тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх бодлогыг дэмжиж ажиллах
- ❖ Биеийн тамир, спорт, идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр дамжуулж гэр бүл, иргэдийг чийрэгжүүлэх чиглэлийн бүхий л үйл ажиллагааг дэмжин ажиллах
- ❖ Эрүүл амьдралын зөв дадлыг дэмжсэн орчин нөхцлийг бүрдүүлэх
- ❖ Боловсролтой, суралцах чадвартай, ёс суртахууны зөв хандлагатай Монгол хүүхдийг сургаж хүмүүжүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх



- ❖ Ерөнхий боловсролын сурууль, цэцэрлэгийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд дүгнэлт хийлгэж, төрөөс хүүхдэд ээлтэй гадаад орчныг бүрдүүлэх, сургуулиудад байгалийн ухаан, хөгжим, технологийн хичээлийн лаборатори байгуулах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх

#### **Иргэдийн оролцоотой хот:**

- ❖ Орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хийгдэж буй ажил үйлчилгээний чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд олон нийтийн оролцоог хангаж, сайжруулах механизмыг нэвтрүүлэх
- ❖ Хот төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн бодлогын төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа бүрт төлөвлөхөөс эцсийн үр дүн гарах хүртэлх үйл явцад иргэдийн оролцоог хангах
- ❖ Хоггүй хот болох зорилтыг дэвшүүлж, хог татан авалтыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх
- ❖ Монгол улсын түүх, соёл, зан заншлыг сурталчлах, монгол дархлааг бий болгох чиглэлээр холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах
- ❖ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, иргэдийн хууль, журам дүрмийн хүрээнд тавьсан санал хүсэлтийг шуурхай, бодитой шийдвэрлэхэд хяналт тавьж ажиллах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- ❖ Өндөр настан, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын чиглэлээр иргэд, олон нийттэй хамтран ажиллах, санал санаачлагыг дэмжих
- ❖ Ажил эрхлэх бүхий л боломжийг нэмэгдүүлж, дундаж орлоготой иргэдийн нийгэмд эзлэх хувийг тасралтгүй нэмэгдүүлэхийг зорино.

#### **Бусад:**

- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулж холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах
- ❖ Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах, утаагүй түлшний үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэхэд төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт тавих
- ❖ Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, хэмнэлтийн бодлогыг баримталж, түүнд хяналт тавих
- ❖ Эмч, эмнэлэгийн ажилтны мэдлэг чадвар, ёс зүйн төлөвшлийг сайжруулах, орчин үеийн эмчилгээ оношилгооны аргыг орон нутагтаа нэвтрүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ажлыг дэмжин хэрэгжүүлэх
- ❖ Иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах
- ❖ Хүнд сурталгүй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг чадавхижуулах, төсвийн зардлыг хэмнэх бодлого баримтлана.

БОЛОВСРУУЛСАН:

Б.ӨЛЗИЙСАЙХАН